



“Амьдралын эх-Ус” “Усны эх-Мод”

*Хүнсээ нэмэгдүүлэхийн тулд
хөрсөө хамгаалж, хөрсөө
хамгаалахын тулд мод
тарих хэрэгтэй.*





Өрхийн аж ахуйд болон бусад
зорилгоор тариалж хүнсний
хэрэгцээгээ хангахаас гадна мөнгө
олох боломжтой моднууд

- 
- ☐ Үхрийн нүд
 - ☐ Чацаргана
 - ☐ Нохойн хошуу
 - ☐ Үрэл

- ☐ Буйлс
- ☐ Тэхийн шээг
- ☐ Алим
- ☐ Чавга.....бусад

Тохижилт, ногоон
байгууламжинд ашиглах
зориулалтаар тариалж
болох моднууд

- 
- | | |
|---------------------------------------|---|
| ☐ Шар хуайс | ☐ Буйлс, Гүйлс |
| ☐ Хайлаас | ☐ Голт бор |
| ☐ Улиас | ☐ Тэхийн шээг |
| ☐ Нохойн хошуу | ☐ Үрэл |
| ☐ Монос | ☐ Бусад шилмүүст мод |

Мод тарих арга

Үрээр тарих

(Хайлаас, шар
хуайс, шинэс,
нарс, долоогоно,
монос)

Мөчрөөр тарих

(Бургас, улиас)

Ногоон мөчрөөр тарих

(Чацаргана, үхрийн
нүд, тэхийн шээг,
нохойн хошуу,
үрэл, голт бор,
буйлс, гүйлс)

“

*Үхрийн нүд,
Алим, Хайлаас
зэрэг модыг
хэрхэн тариалах
талаар*

“Үхрийн нүд” жимсний модыг тариалах талаар

Суулгац тарих хугацаа

- ❑ Хаврын тариалалт:
Жил бүрийн IV/20-V/10
(Гэхдээ нахиа задраагүй байх шаардлагатай)
- ❑ Намрын тариалалт:
Жил бүрийн IX/20-X/20

Тайлбар: Өөр бусад мод, бутыг тариалах хугацаа
дээрхтэй адилхан байна.



Үхрийн нүд



Р, С, В1, В2 аминдэм, уураг, пектин,
сахар, аскорбины хүчлээр баялаг

Хөхүүлэн
ханиалгах,
хавагнах үед
буцалгаж
хэрэглэнэ

Хоол идэх хүслийг
нэмэгдүүлэх

Ходоод гэдэсний
үйл ажиллагааг
сайжруулах




Үхрийн нүд тарих үйл ажиллагааны дараалал


- ❑ Үхрийн нүд нь үржил шим ялзмагаар баялаг карбонатгүй 5,5-6 рН-тай хөрсөнд ургадаг. Зөв арчилж ургуулсан тохиолдолд 9 ба түүнээс ч олон жил ургаж нэг бутнаас жилд 4-6 кг жимс өгдөг бутлаг жимсний мод юм.
- ❑ Үхрийн нүд тарих ажил дараахи дарааллаар хийгдэнэ.
 1. Хөрсөө хагалж, боловсруулж бэлтгэх
 2. Тарих газраа хэмжиж тэмдэглэх
 3. Суулгах нүхээ ухах
 4. Хөрсөө хольж бэлтгэх
 5. Бэлтгэсэн хөрсөө ухсан нүхнийхээ 3-ны нэг хүртэл хийх
 6. Суулгацаа суулгах
 7. Услах
 8. Тайралт хийх

Эхний 7 ажиллагаа бусад төрлийн мод, бутыг тариалахад адилхан хийгдэнэ,

Хөрс бэлтгэж суулгах газраа хэмжих




1. Ямар ч төрлийн мод тарих хөрсний өнгөн хэсгийг 30 см орчим эргүүлэн хагалж зэрлэг ургамлыг устгаад тэгшилнэ.




2. Үхрийн нүдийг 2 x 1-1,5 м хэмжээтэй суулгахаар тэмдэглээд нүхээ ухаж эхлэнэ.

Нүх ухаж, хөрсөө бэлтгэх




Нэг нүхний хэмжээ 35-40см гүнтэй, 50-60 см голчтой (диаметртэй) байна.




Нүхээ ухсаны дараа хөрс бэлтгэхдээ ухаад гарсан шороо 70%, бүрэн ялзарсан бууц эсвэл багсармал бордоо 30% байна.

Бэлтгэсэн хөрсөө ухсан нүхэндээ хийж, суулгацаа байрлуулах




Бэлтгэсэн хөрснөөсөө ухсан
нүхнийхээ голд нүхний өндрийн
3-ны нэг хүртэл овойлгон хийнэ.




Суулгацын үндэсний хүзүүг
овоолсон хөрснийхээ дээр
байрлуулж үндсийг тал талруу
нь тараан байрлуулна.

Суулгах, услах



Үндэсний хүзүүнээс дээш 10 см
орчим булагдахаар тооцож
бэлтгэсэн хөрснийхээ үлдэгдлийг
хийж маш сайн гишгэж нягтруулна.




Услахдаа 60-80 л усаар услана.
7-14 хоноод дахин дээрхи
нормоор услана. Цаашид сар бүр
20-30л усаар услана.

Тайралт хийх




Тарьсан суулгацынхаа хөрснөөс
дээш гарсан хэсэгт 3-4 нахиа
үлдээж хайчлаад будаж орхино.




Ингэж тайралт хийхэд хөрсний дээр ил
гарсан нахиа бүрээс мөчир ургахаас
гадна хөрсний доорхи унтмал
нахианууд сэргэж шинэ мөчрүүд ургаж
гарч ирнэ.

Титэмлүүлэх




Намар нь мөчир бүрийг хөрснөөс дээш гарсан хэсэгт 3-4 нахиа үлдээж тайрна. 2 дахь жилийн хавар газар гэсэнгүүд бут бүрийг 4-5кг ялзарсан бууцаар бордож 40-50л усаар услана.




Ингэж тайрахад дараа жил нь тайрсан нахиа бүрээс мөчир гарахаас гадна мөн унтмал нахианууд сэргэж олон мөчир үүсгэнэ. Ингэж тайрахыг титэмлүүлэх гэж нэрлэх бөгөөд хичнээн олон мөчиртэй байх тусмаа төдий хэмжээний их жимс өгөх болно.

Арчилгаа



Үхрийн нүд хавар 5-р сарын сүүлчээр цэцэглэх ба энэ үедээ цэцэг нь хяруунд цохиулж жимсний ургац алдах нь их байдаг учир цочир хүйтрэлттэй үед хучиж байна.



Үхрийн нүдний модыг жил бүр 35-40 мөчиртэй байхаар тооцоолж үхсэн мөчирүүдийг түүж хаяж байна. Хажуугийн мөчрийг дарж үндэс үүсгэх замаар шижмээр үржүүлж болно.

Үхрийн нүдний хортон, тэмцэх арга



- ☐ Үхрийн нүдний нахианы хачиг
- ☐ Аалзан хачиг
- ☐ Үхрийн нүдний хивэн
- ☐ Тошлойн цох эрвээхэй
- ☐ Тошлойн төөлүүрч



Үхрийн нүдний нахианы хачиг, түүнтэй тэмцэх арга




- 1.Бие гүйцсэн хачгийн томруулсан зураг
- 2.Идэгдсэн мөчир
- 3.Хачиг халдварласан нахиаг зүсэж үзүүлсэн байдал
- 4.Бие гүйцсэн хачгийг бага зэрэг томруулж хажуугаас нь харуулсан байдал

Тэмцэх арга:

- Эрүүл суулгацаар тарих
- Хуучин үхрийн нүд тарьж байсан газраас 1.5 км-с ойргүй газар эх ургамлын талбай байгуулж тусгаарлалт хийх
- Бага хэмжээний талбайд цөөн тооны бут тарьсан бол хавар ургаж эхлэхээс өмнө өвчилсөн нахиаг түүж устгах
- 50%ийн карбофосын уусмал ба децисийг 10 л усанд усанд 30 гр-аар найруулаад цэцэглэхийн өмнө, цэцэглэсэний дараа шүрших
- Цэцэглэх үед 100гр саримсыг жижиглээд 10л усанд найруулж ханд бэлтгэн шүрших

Аалзан хачиг, түүнтэй тэмцэх арга



- 0,5 мм орчим биетэй маш жижгхэн шаравтар улаан *өнгөтэй* навчны доод талд байрлаж шүүсийг нь сорж гэмтээдэг.
- Ихэвчлэн үхрийн нүдийг гэмтээнэ.

Тэмцэх арга:

- Намар хагдарч унасан навчийг түүж шатаах
- 50%- ийн карбофосын уусмал ба децисийг 10л усанд усанд 30гр-аар найруулаад цэцэглэхийн өмнө, цэцэглэсэний дараа шүрших
- Саримасны хандаар шүрших.

Үхрийн нүдний хивэн

(Тошлой, үхрийн нүдний навчийг идэж, зөвхөн бариулыг үлдээдэг)



1,2, Эрвээхэй
3, Хивэнгийн төөлүүр
өвөлжих үүр. Мөчрийн
хуурсан холтсонд байгаа нь
4, Хивэнгийн төөлүүр
5,7,8 Хивэнгийн гэмтээсэн
нахианууд
6, Төөлүүрийн хөгжлийн үе
9,10 Авгалдайн хөгжлийн үе


Тошлойн цог эрвээхэй, түүнтэй тэмцэх арга



1. *Бие гүйцсэн эрвээхэй*
2. *Төөлүүр*
3. *Халдвар авсан мөчир*

- Намар тошлой, үхрийн нүдний бутны ёроолын хөрсийг хагалж бутыг 10-12 см манаж өгвөл ирэх жилийн хавар эрвээхэй гарахыг саатуулна
- Тошлой үхрийн нүдийг цэцэглэсний дараа карбофос ба децисийн 0,3%-ийн уусмалаар шүршинэ. (1 л усанд 3 гр-аар хийж найруулна)

Тошлойн төөлүүрч, түүнтэй тэмцэх арга




1, Эрвээхэй

2, Төөлүүр тошлойн
мөчрийг сүйтгэж байгаа нь

- Унасан навчийг түүж шатааж цэвэрлэнэ.
- Хавар эрт төөлүүр гарах үед түүхий шохой шүршинэ.
- Өндөгнөөс гарсан төөлүүрийг карбофос ба децисийн 0,3%-ийн уусмалаар шүршинэ.

Аалзан хачиганд гэмтсэн үхрийн нүд

А.



- А, Эрүүл навч
- Б, Хортонд нэрвэгдэж хатаж хуйларсан навч
- Хортон навчны ар ба навчны ишний угийн хэсэгт байрласан байдал



АЛИМ (Malus.L)

Сортын нэр: Алтайская Румяная
(Бэсрэг алим сорт)

Амьдралын хэлбэр	Модлог
Өндөр	Дундаж
Титэм	Дугуй
Жимс	Бөөрөнхий улаан өнгөтэй, зарим хэсгээрээ цайвар судалтай
Жимсний жин	55-90 гр
Амт	Махлаг эд нь шаргал, шүүслэг, амтлаг, баг зэрэг исгэлэн, дунд зэргийн нягтралтай, сулхан үнэртэй.
Жимсний боловсролт	VIII сарын сүүлээр
Жимслэлт	Суулгаснаас хойш 4-5 жилийн дараа
Жимсийг хадгалах хугацаа	60 хоног хүртэл
Ургац	Жимсний 7 жилийн дундаж ургац 12.0 тн/га, хамгийн их ургац 26.7 тн/га
Хүйтний тэсвэр	Хүйтэнд тэсвэртэй
Сортын давуу тал	Өвлийг сайн давдаг, тогтмол жимсэлдэг, өвчин хортонд тэсвэртэй.
Сул тал	Жимс хурдан унадаг.




Алимны (Malus) төрлийн ургамал нь мод, сөөг хэлбэрийн мод. Сибирийн гаралтай, хүйтэнд тэсвэр сайтай, хөрс, цаг уурт дасах чадвараар гойд гэрийн (Malus Domestica) алимыг тарьж ургуулах нь тохиромжтой.



Алимны төрөлд 36 зүйл байдгийн нэг зүйл жимст алим буюу өрөл (Malus baccata L Borkh) нь манай нутагт зэрлэг ургадаг. Алимны ихэнх сортууд суулгаснаас хойш 4-5 жилийн дараа үр жимсээ өгч эхлэх ба уур амьсгал зөөлөн, хөрс сайтай, тохиромжтой нөхцөлд ургуулсан алимны цэцэрлэгийн нэг га талбайгаас 20-30 тонн ургац авдаг. Алимны мод урт насалж, 70-80 жил амьдарна.



АЛИМ УРГУУЛАХ ТЕХНОЛОГИ




Талбай сонгох:

Алим тариалах талбай нь урагшаа харсан чиглэлтэй, наранд ээвэр, хүйтэн салхинаас хамгаалагдсан тэгшдүү налуу, энгэр дулаан газар байвал сайн. Хөрсний гүний усны түвшин 1.5-2 м-ээс доош байвал зохино. Цэцэрлэгт үржил шим сайтай хар шороон ба хөнгөн хүрэн хөрс илүү тохиромжтой. Харин шаварлаг, хужир марзтай газарт зориудын бэлтгэл хийхгүйгээр цэцэрлэг байгуулж болохгүй.

Улаанбаатар хот орчмын намгархаг, цэвдэгтэй хөрсөнд тохиромжгүй. Нүх ухахад 40-50 см-т ус шүүрдэг бол тариалахгүй байхыг анхаарах.

Хөрсийг бэлтгэх:

Алимны мод тариалахад урьдчилан сонгосон талбайдаа ажиглалт хийж шаардлагатай бол дов сондуул, мод бут, чулуу, бусад хог ургамлыг авч зайлуулан, хонхор, гүдгэр хэсгийг тэгшлэх арга хэмжээ авна. Хөрс нь үржил шим сайтай дунд зэргийн механик бүрэлдэхүүнтэй дулаан, ус, агаарын горим тохиромжтой байвал зохино. Алимны мод суулгах нүхийг 1 метрийн диаметртэй, 50 см-ээс доошгүй гүн ухаад, түүндээ бууц, эрдэс бордоо, шорооны холимогтой хийхээр бэлтгэнэ. Мод суулгахын өмнө 40-50 см-ээс доошгүй гүнд хавж сийрүүлээд, борнойдоно. Талбайг хэсэгчлэн хуваасны дараа 1.0-1.25 метрийн диаметртэй, 50-60 см гүн нүх ухаж бэлтгэнэ. Нүхийг гараар ухвал өнгөн хэсгийн шороог нэг талд нь овоолно






Алимны суулгац суулгах:

- Алимны суулгацыг суулгахын өмнө гүн шан татаж түүндээ хийгээд үндсийг нь чийгтэй хөвд, шороогоор дарж түр хадгална.
- Суулгацын үндсийг ус, шорооны зуурмагт байлгаж байгаад авч суулгана.
- Хаврын суулгалт намрынхаас илүү үр дүнтэй байдаг. Алимны модыг IV сарын сүүлч, V сарын дунд хугацаанд багтаан суулгана.
- Алимны модыг эгнээ хооронд 5 метр, ургамал хооронд 3 метрийн тэжээлийн талбайтайгаар суулгана.

Алимны суулгацын чанарын үзүүлэлт

№	Үзүүлэлт	1	2
1	Их биеийн өндөр, см	50-65	40-60
2	Ишний бүдүүн, см	5-9	5-8
3	Ишний салаа, ширхэг	2-3	1-2
4	Үндэсний урт, см	20-30	15-25
5	Үндэсний салаа, ширхэг	6-8	5-7




Суулгацыг тээвэрлэх замд үндэс нь хатвал 12-24 цагийн туршид ус, шорооны зуурмагт дүрнэ. Үндэсний хаталт нь суулгацын амьдралыг эрс бууруулдаг учир тээвэрлэх үедээ үндсийг чийгтэй шороо, үртэсээр сайн хучих хэрэгтэй.

Мод суулгах нүхэнд ялзарсан бууц 15-20 кг, суперфосфат 0.5-1 кг, азот 0.3 кг, кали 0.1 кг-ыг шороотой сайтар хольж, хийнэ.

1-2 настай, өсөлт хөгжилт сайтай, үндэс сайн суусан суулгацыг сонгон авч тариална.

Суулгацыг модны үндэсний хүзүү нь газрын гадаргуугаас 4-5 см дээр байхаар бодолцож, тохируулна. Суулгахын өмнө үндэсний гэмтсэн хэсгийг хурц хутгаар эсвэл хайчаар эрүүл хэсэг хүртэл нь тайрна.



Суулгацыг нүхэнд тэгш барьж, шороогоор булна. Үүний дараа шороог эргэн тойронд нь нягтруулж гишгэнэ. Үндсийг 10-15 см зузаан шороогоор булаад ус тогтоох тогоо хийж, үүний дараа 40-60 литр усаар услана. Усалгааны тогоо гол 1.5-2 метр байх ба дараагийн 2 жилд 0.5 метрээр өргөсгөж, 3.5 метрт хүргэнэ. Усалгааны дараа хөрсөө сийрүүлж шороо, ялзмагаар хучина. Ингэснээр чийгийн алдагдлыг бууруулна. Суулгалтын дараа суулгацын газрын дээрх хэсгийг богиносгож тайрах нь түүний амьдралтыг идэвхижүүлж өгдөгийг анхаарах хэрэгтэй. Модыг суулгасны дараа гадаслаж уяж өгнө.

Суулгалтын дараах арчилгаа:

Суулгацыг сэргэн ургаж эхэлтэл 7-10 хоногийн зайтайгаар усална. Мөн шилбэ орчмын хөрсийг хатахаас хамгаалж 5-6 см зузаан шороо буюу бууцаар хучлага хийж өгнө.

Усалгаа:

Анхны усалгааг нахиа задралтын өмнө IV сарын сүүлч, V сарын эхээр өгч, цэцэглэлтийн дараа дахин услана. Мөчрийн хамгийн эрчимтэй өсөлтийн үед VI сарын сүүлийн арав хоногт 3 дахь усалгааг хийнэ. Мөн жимсний томролтын үед хур багатай байвал услах шаардлага гардаг. Ургалтын хугацааны II хагаст гандуу халуун байвал ургац хураахаас 20-26 хоногийн өмнө услах хэрэгтэй. Усалгааг сувгаар эсвэл тогоонд зөөж хийх ба 60 см хүртэл гүнд хөрс сайн норсон байхаар тооцож услана. Усалгаа бүрийн дараа 2-3 хоногийн дотор тогоо буюу сувгийн доторх хөрсийг сийрүүлнэ. IX сарын сүүлч, X сарын эхээр модны навч унах үеэр буюу газар хөлдөхийн өмнө намрын цэнэг усалгаа хийнэ. Манай нөхцөлд нэг удаагийн усалгаагаар 500-600 м³/га-аас доошгүй усаар усалж, үндэс тархсан давхаргыг бүрэн норгосон байх шаардлагатай.

Бордох:

- Хавар модны нахиа хөөх үе шатанд азотоор бордож, 2-3 долоо хоноод азотын бордоогоор дахин бордоно.
- Намар кали, фосфорын бордоогоор бордож, модны өвлийн тэсвэрийг нэмэгдүүлнэ.
- Үхрийн баас юмуу шувууны сангасны шингэн 8-10л-ийг модныхоо шилбэ орчимд хийнэ.

Суулгасны дараах жилүүд	Нүхний голч (диаметр)-ийн хэмжээ, м	Бууц, кг	Эрдэс бордоо, гр		
			Азотын бордоо	Супер фосфот	Калийн давс
1-2	1.5-2	12-15	50	100	30
3-4	2.5	15-20	75	150	50
5-6	3.0	20-30	100	210	70

Модыг хэлбэржүүлэх:

Модны хажуугийн мөчрүүдээс өөр хоорондоо 15-20 см ургасан өсөлт сайтай 2-3 мөчрийг үндсэн мөчрөөр нь үлдээж, төвийн гол дамжуулагчийн дөрөвний гурвыг хяргаж, дараа жилээс угаар тайрч хаяна.



Өвчин, хортон шавьжаас хамгаалах арга:

Алимны талбайд долоогоны цагаан эрвээхэй зэрэг хортон шавьжууд тохиолдог. V сарын эхээр нахиа хөөх үеэр хлорфосын уусмалаар (10 литр усанд 20-30 гр хор) шүршинэ.



Алимны үр идэгч, навч хуйлагчтай тэмцэхдээ модны цэцэглэлтийн өмнөх үеэр модны шилбэ орчмын 1 м² талбайд 50 гр дуст цацаж, модны титмийг метафос, тиофосын 0.5%-ийн (10 литр усанд 5 гр хор) уусмалаар шүршинэ. Цэцэглэлтээс хойш 14 хоногийн дараа дээрх уусмалаар дахин шүршинэ. Мөн 3 дахь шүршилтийг долоодугаар сарын эхний 10 хоногт явуулж болно.





Өвөлд бэлтгэх:

- Дулаан хуурай үед модыг будна. Шингэн цагаан эмульсэн будгийг хэрэглэж болно.
- Мөн хучиж өгнө зэгэс сүрэл 5-10 см зузаан шороогоор газар хөлдөхөөс өмнө хучиж өгнө.

АРИУН МОД ГЭЖ НЭРЛЭДЭГ ГАЙХАМШИГТ ХАЙЛААС МОДНЫ ТАЛААР




- Дэлхий дээр 40 гаруй зүйлийн хайлаас Европ, Баруун ази, Африкт голлон тархсан ба халуун дулаан орны хайлаас нь маш хүчирхэг, 25 - 40 метрээс багагүй өндөртэй, их хэмжээний мөчир салаа бүхий нягт шигүү титэмтэй, нүүрс хүчлийн давхар ислийг сайн шингээдэг, хүчилтөрөгчийг бусад модноос илүү их ялгаруулдаг.
- Манай орны хувьд Тарваган /Одой/ хайлаас, Том үр жимст хайлаас, Япон хайлаас гэсэн 3 зүйл хайлаас тархан ургадаг

МАНАЙ ОРОНД УРГАДАГ ХАЙЛААС МОДНЫ ОНЦЛОГ ШИНЖ

- ❖ Манай орны хайлаас 3 -15 м хүртэл янз бүрийн өндөртэй, холтос зузаан, шарлангуй үнэсэн саарал өнгөтэй, туушдаа муруйж хагарсан байдаг, залуу мөчир шар өнгөтэй, навчны хэмжээ харилцан адилгүй, харьцангуй жижиг, өргөн юлд хэлбэртэй, хосолсон хөрөөлөг захтай. Харин тарваган хайлаас дунд зэргийн хэмжээтэй боловч говьд онцгой том хайлаас элбэг тохиолддог.
- ❖ Овор хэмжээ, амьдрах хугацаа, ургах онцлог зэргээрээ халуун орныхыг гүйцэхгүй боловч эх газрын эрс тэс уур амьсгалд нэн сайн зохицон өөрийн өвөрмөц дүр төрхийг бий болгож чадсан гайхамшигтай сайхан модны нэг юм.

- 
- 
- ❖ Гандалтанд орсон үедээ ууршилтаа маш их хэмжээгээр багасгаж гандалтыг хохирол гэмтэлгүйгээр давж гардаг онцлогтой. Ялангуяа хөрс, агаарын урт хугацааны гандалтын үед навчныхаа 50 хүртэл хувийг богино хугацаанд унагах замаар хамгаалж чаддаг байгалийн зохилдлоготой, өөрөөр хэлбэл хайлаас нь ганг сайн мэдэрч, түүнээс өөрийгөө хамгаалах чадвар бүхий мэдрэмтгий ургамал учир экологийн янз бүрийн нөхцөлд дасан зохицож тархан ургадаг цөөхөн ургамлын нэг юм.
 - ❖ Хайлаас нь жил бүр 4–р сарын 15–ны орчимд, харин Хангайд 5–р сарын нэгний орчимд цэцэглэнэ. Салхиар тоос хүртэж сайн үрлэнэ. Үр нь салхиар тархах зохилдлого бүхий нисгүүр далавчтай, түүнийхээ гол дунд үр нь байрлана, 1000 үрийн жин 5-6 гр орчим, бөгөөд хавар эрт 5-р сарын сүүлчээс 6 сарын дунд үе хооронд үр нь боловсорч унадаг тул үрийг нь түүж авч хатааж цэвэрлээд 3-5 хоногийн дараа тарьж, арчилж ургуулан намар гэхэд нэг настай тарьц бэлэн болж хугацаа хожих боломж бүхий ургамал юм.

- 
- 
- ❖ Нөгөө талаар хайлаас нь 2 янзын үржлээр үрждэг үржлийн өндөр чадавхитай ургамал учир хаана ч, аль ч аргаар нь үржүүлж ашиглах бүрэн боломжтой.
 - ❖ Хайлаас нь дээрхи онцлог шинжүүдээс гадна янз бүрийн аргаар огтолж танан олон хэлбэрээр ургуулж болдог таналт огтлолтонд нэн тэсвэртэй ургамал учир хот суурингийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн гол ургамал болдог.
 - ❖ Ялангуяа өвчин, хортон бараг (урын ялаанаас өөр) байхгүй, навч, иш мөчир, гишүүгээр нь мал тэжээх, холимог тэжээл үйлдвэрлэх, гоёл чимэглэлийн гэх мэтийн олон талын ач холбогдолтой үнэт ургамал учраас ойн төрөл бүрийн зурвасууд болон агро ойжуулалтанд өргөн тарьж байгаль орчноо хамгаалах, цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх өндөр ач холбогдолтой мод учраас “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор тариалалт хийхэд эерэг сайн үр дүн гарна.

Хайлаас ургуулах арга, арчилгаа

- ❖ Үрээр үржүүлнэ. Үр нь хавар 5 дугаар сарын сүүлээр боловсорч маш богино хугацаанд унадаг. Иймд үрийг түүгээд шууд тарих бололцоотой. Үрээ тарихын өмнө 1-2 цаг чийглэн дэвтээсний дараа тарина.
- ❖ Нэг га-д цэвэр үр дунджаар 120 кг ноогдохоор бодож далавчтай нь 0.5-1 см гүнд үртэс ба хөнгөн хөрсөөр хучиж тарина. 2-3 настай тарьцыг бойжуулах болон ойжуулалт, цэцэрлэгжүүлэх ажилд шилжүүлэн суулгана.
- ❖ Үрийг бага даралттай усаар шүршиж жигд соёолуулна. Соёолсны дараа шуудуугаар усална. 5-7 хоногт тогтмол услах ба хур бороо элбэг үед услах шаардлагагүй болно.
- ❖ Хөрсийг 7 хоногт нэг удаа сийрүүлнэ. Хог ургамлыг тогтмол зулгааж зайлуулна. Хоёр настайгаас нь суулгацын доод хэсгийн найлзуурыг таслан авч гол ишийг гаргах замаар хэлбэржүүлэхэд анхаарах хэрэгтэй. Хэлбэржүүлэлтийг жил бүр тогтмол хийвэл хайлаас өндрөөшөө түргэн өсдөг тул буталж ургахыг зогсоодог сайн талтай.



“Бэлчэрийн менежмент төслийн нэгж” - ОНӨТҮГ